

АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Нийтийн биеийн тамирын арга хэмжээ:

Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Монгол улсын их хурлын 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” зорилт 3.5.1, Монгол улсын Ерөнхийлөгчийн “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн зэрэг заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор “Бүх нийтийн гүйлт”-ийн намрын хаалтын арга хэмжээг зохион байгууллаа. Нийт давхартсан тоогоор 400 гаруй төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэд хамрагдсан.

“Би сэлж сурлаа-II” сургалтын аян 3 сарын богино хэмжээний түргэвчилсэн сургалт 2024 оны 9 сарын 20-иос эхлэн 12 сарын 20-ийг хүртэл үргэлжлэх бөгөөд 4-11 насны 150 хүүхэд хамрагдав.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 53 дугаар зарлиг, Эрүүл мэндийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын хамтарсан 2019 оны А/736 дугаар тушаалын хүрээнд ББТТ сорилыг аймгийн төвийн 11 цэцэрлэг, 5 сургууль, аж ахуй нэгж, албан байгууллага, 12 сумын сургууль цэцэрлэгээс авч ажиллаж байгаа бөгөөд цахим санд 3299 сорилд хамрагдсан мэдээ шивэгдсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулж байгаа “Эрүүл монгол хүн” хөдөлгөөний хүрээнд 2024 оны 11 сарын 30-наас 12 сарын 25-ны хооронд төрийн байгууллагуудад хууварь гарган өглөөний 7:00-8:30 цагийн хооронд 33 төрийн байгууллагын албан хаагчид “Эрүүл зөв хооллолт”-ын сургалт, бие халаалтын дасгал болон иогийн дасгал хийж, спортоор үнэгүй хичээллэх боломж нөхцөлөөр хангасан.

Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, олон нийтийн оролцоог хангах, сурталчлах ажлын хүрээнд орон даяар зохион байгуулагдаж буй “Биеийн тамир, спортын бүтээлч сар-2024” арга хэмжээний хүрээнд Баруун-Урт сумын ерөнхий боловсролын сургууль болон МБТ-ийн сурагчдыг шинээр орсон спорт цогцолборыг танилцуулах, үнэ төлбөр үйлчлэх ажлыг зохион байгуулав.

Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жилийн ойн баярт зориулсан Эрдэнэмандал хийдтэй хамтран “Тусгаар тогтнол-Эрдэнэмандал” цомын төлөө өсвөр үеийн 128 хүчит бөхийн барилдааныг зохион байгуулав.

Тайлант сард нийтийн биеийн тамирын 27 арга хэмжээ, давхартасан тоогоор 200 аж ахуй нэгж, албан байгууллагын дунд зохион байгуулан, давхартсан тоогоор 7749 хүүхэд, залуучууд, иргэд, хөдөлмөрчид хамрагдсан байна.

Улсын аварга, Бүсийн нэрэмжит, ААШ шалгаруулах тэмцээн:

Кипр улсын Ларназа хотод зохион байгуулагдсан самбо бөхийн өсвөрийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 1 хүрэл медаль, Өвөр Монголын өөртөө засах орны Шилийн гол аймаг зохион байгуулагдсан жүдо бөхийн өсвөрийн олон улсын тэмцээнээс 4 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 1-р байр, Улаанбаатар хотод болон налайх дүүрэгт зохион байгуулагдсан чөлөөт бөхийн өсвөр үеийн Олон хотын тэмцээнээс 2 мөнгө, 4 хүрэл медаль, Монголын усан спорт сонирхогчдын холбооны ерөнхийлөгчийн цом тэмцээнээс 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль, Завхан аймагт зохион байгуулагдсан Завхан цом жүдо бөхийн өсвөр үеийн олон хотын тэмцээнээс 1 алт, 1 мөнгө, шилдэг эмэгтэй тамирчинаар тус тус шалгарсан.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан U13 насны сагсан бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль, Аэробикийн баг клубын өсвөр үеийн улын аварга шалгаруулах тэмцээнээс 1 мөнгө, 6 хүрэлмедаль, Өсвөр, залуучуудын үндэсний бөхийн Монгол Улсын аварга шалгаруулах барилдаанд баг тамирчдын бэлтгэл сургуулилтыг ханган оролцуулсан.

Мөнхсайн-Үүд ххк-ний Дижитал фото төвийн 20 жилийн ойн зүүн бүсийн Өсвөр үеийн аварга шалгаруулах Шатрын тэмцээн 2024 оны 10 сарын 19,20-ны өдрүүдэд зохион байгуулав. Тус тэмцээнд Багануур, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн 140 гаруй шатарчид 10,000,000₮-ийн шагналын сантай 28 багц медаль болон багийн цомын тэмцээнээс 1-р байранд Оюунлаг шатрын холбоо шалгарав.

Өсвөр үеийн Аймгийн аварга шалгаруулах самбо бөх, усан сэлэлтийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, насанд хүрэгчдийн жүдо, самбо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг тус тус зохион байгуулан ажиллав.

Хамтарсан бэлтгэл сургуулилт, сургалт:

Герман улсын мэргэжилтэн, Монгол улсын шигшээ багийн дасгалжуулагчын удирдлаган дор хөл бөмбөгийн өсвөрийн шигшээ багийн тамирчид болон хөл бөмбөгөөр хичээллэх сонирхолтой хүүхэд багачуудад 2 өдрийн кемп сургалтыг зохион байгуулав. Уг сургалтанд нийт 400 тамирчин, хүүхэд багачууд хамрагдав.

Дугуйн спортын өсвөрийн тамирчин Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох бэлтгэл сургуулилтаа Улаанбаатар хотод спортын дунд сургуульд дээр хангасан.

Сургалт:

Биеийн тамир спортын салбарын II зөвлөгөөн 2024 оны 12 сарын 13ны өдөр зохион байгуулагдаж, биеийн тамирын багш, хамтлагийн арга зүйч, спортын холбоод, клубын тэргүүнүүд, биеийн тамир спортын зүтгэлтнүүд нийт 120 төлөөлөгч, мөн аймаг сумын удирдлагууд оролцов. Зөвлөгөөнөөр салбарын үйл ажиллагаа түүнд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэв.

Үндэсний бичгийн анхан шатны сургалтыг 7 хоногийн даваа, лхавга, баасан гаригууд 1 цагийн сургалтыг тогтмол авч, 7 хоног бүрийн даваа гариг бүр уншлага, хуулан бичгийн цагтай болсон.

АЗДТГ, Нийтгмийн бодлогын хэлтэс, Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо хамтран “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай” сургалтанд Биеийн тамирын хэлтсийн дарга хамрагдав.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжилтийг сайжруулах, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, мониторинг хийх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үр дүнд суурилсан үнэлгээ мониторингийн тогтолцоог хөгжүүлэхээр шинэчилсэн журмын төсөл танилцуулах, хэлэлцүүлэг болон "Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт: Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сэдэвт сургалтанд танхим болон цахим хэлбэрээр хамрагдсан.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагддаг 7:4:10 сургалтанд тогтмол хамрагдан ажиллаж байна.

Дотоод үйл ажиллагаа:

Спортын цогцолбор, спортын “А”, “Б” заал, Усан спорт, чийрэгжүүлэлтийн төвд секц, дугуйлангийн үйл ажиллагаа хуваарийн дагуу тогтмол хичээллэж байна.

2024-2025 оны секц, дугуйлангийн нээлтийн өдөрлөгийг 2024 оны 10 сарын 19-ны өдөр спортын 15 төрлөөр зохион байгуулав. Тус өдөрлөгөөр спортын холбоод, клубын үйл ажиллагааг сурталчлан таниулах, иргэд, өсвөр үе, залуучуудыг спортоор хичээллэхийг уриалан, биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилготой.

Мөн өсвөрийн шигшээ багийн тамирчид үзүүлэх тоглолт хийж, тухайн спортын төрлийн давуу талууд, ур чадваруудыг харуулав.

Усан спорт чийрэгжүүлэлтийн төвийн усан сангийн ариутгал халдваргүйжүүлэлтын үйл ажиллагаанд 137кг 2,260,500 төгрөгийн ариутгалын бодис, 15ширхэг 825,000төгрөгийн ус тунгалагжуулагч, РН хасах бодис 10ширхэг 660,000 төгрөгийн бодис нийт 3,745,500 төгрөгийн бодис тус тус зарцуулсан байна.

Хог хаягдлын тухай хуулийн 10.2.10 өөрийн байгууллагын эзэмшлийн 4 объектын 50м талбайн хог хаягдлыг цэвэрлэж, хогийн цэгт тээвэрлэн ажилласан.